



CENTRAL
GEOLOGICAL
LABORATORY
www.cengeolab.com

Монголд эрдсийн шинжилгээний
тухай яригдвал

ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Гадаадад томилолтоор ажиллуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.10 заалт, Гадаад улсад болон орон нутагт албан томилолтоор ажиллах журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт, Төрийн Өмчийн Бодлого, Зохицуулалтын Газрын 2018 оны 02 дугаар сарын 28-ны А-4/561 тоот бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын захирал Өлзий овогтой Оюунбаатарыг Канад улсын Торонто хотод зохион байгуулагдах Олон улсын уул уурхай, хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт /PDAC-2018/-д 2018 оны 03 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд томилон оролцуулсугай.
2. Албан томилолтын удирдамжийг 1-р хавсралтаар, зардлын төсвийг 2-р хавсралтаар тус тус баталсугай.
3. Төсөвт тусгагдсан 5,754,984.6 /таван сая долоон зуун тавин дөрвөн мянга есөн зуун наян дөрвөн төгрөг жаран мөнгө/-ийг холбогдох эх үүсвэрээс гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнхтуяа/-д зөвшөөрсүгэй.
4. Албан томилолтоор ажиллах хугацаанд аюулгүй ажиллагааны зааварчилга өгөхийг ХАБЭА хариуцсан ажилтан /Д.Чойндонжамц/-д даалгасугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Техник хангамж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал /Г.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛСЭН
ДЭД ЗАХИРАЛ



Л.БАТЗОРИГ

3802262